


1 Гадна дээврийн суурийг бэлтгэх

Уян дээврийн суурь бэлтгэх


Уян дээврийн суурь нь хуурай, нягт, хатуу, тэгш байх ёстой. Хавтангуудын залгаасыг бэхлэлтийн хадаас эсвэл шруүпээр бэхлж өргөн дам нурууг угсрах ба хавтан хоорондын зай 3 мм.



Дэвсгэр хучилт тавих



Дэвсгрийн аль ч налууд дэвсгэр хучилтыг бүхий л талбайд хийх зайлшгүй шаардлагатай. Дэвсгрийн хүрээний залгаас ба хүрээний холбоост ANDEREP (өөрөө наалддаг) эсвэл иймэрхүү төрлийн ямар ч материалыг ашиглаж болно*. Налуугийн бусад хэсгийг ANDEREP (механик фиксацитай) дэвсгэр хучилт эсвэл иймэрхүү чанарын өөр материалаар бүтээгнэ*.

Дэвсгэр хучилт сууринд өргөн тавтай цайрдсан хадааснуудыг 200–250 мм бүрт хадна. Давхардсан хэсгүүдэд ТехноНИКОЛЬ №23 цавууг 8–10 см-ийн өргөнд түрхэнэ.




Дэвсгрийн хүрээний залгаасыг

Дэвсгрийн хүрээний залгаасыг хүрээ дарагчаар бэхлэнэ. Тэдгээр нь дэвсгрийн тусгай хадааснаар 120–150 мм зайтайгаар шатарчилсан байдлаар бэхлэгдсэн байх ба залгаастай хэсэгт 20–30 мм зөрсөн байна. Хүрээ дарагчийн зөрсөн хэсэг нь хоорондоо 30–50 мм зайтай байна.



4 Эгнээний уян дээврийг суурилуулж тогтоох


Хадаас зөв хадах



Эхлэх зурвасыг суурилуулах

Лууны шүд зүсэлтийн хэлбэртэй үед эхлэх зурвас нь эгнээний уян дээврээс урьдчилан зүсэлтгүйгээр тавигдана. Тавих үед ард хэсэгт ТехноНИКОЛЬ №23 цавуу түрхэнэ.

Нэг давхаргатай уян дээврийг суурилуулахад эхний зурвас байдлаар шовх дээврийн хүрээний уян дээвэр эсвэл эгнээний уян дээврийн хэв загварыг (тайрсан дэлбээ бүхий хавтан) ашиглана. Дэвсгрийн хүрээний уян дээврийг хүрээний металл дарагчуудын дээгүүр нугалсан хэсгээс 1–2 см доголтойгоор хадаасаар хадна.



5 Шувуун нуруу, гуяны хэсгийг угсрах

Арга №1


Шувуун нуруу, гуяны хэсгийг энэ аргаар угсрахад нуруулдах уян дээвэр ашиглагдах ба энэхүү уян дээврийг цоолсон газруудад нурууны ирмэг дарагч уян дээврийг гурван хэсэгт хуваан гаргаж авна.

Гуя. Гуя уруу гарсан эгнээний уян дээврийг зэрэгцээ налуунуудын хучлага хооронд 0.5 см өргөнтэй зүссэн байдлаар хасаж тайрна. Нурууны уян дээврийг доороос дээш байрлуулж тавина. Уян дээвэр болгоныг дээр байрлаж байгаа уян дээврийн дөрлөг (3–5 см) нь доор нь байрлаж байгаа уян дээврийн хадаасыг халхалж байхаар дөрвөн хадаасаар (тал бүрээс хоёр хоёроор) хадаж бэхлэнэ.



Нуруу. Хажуу талын нурууны хэсгийн тавилтыг салхины эсрэг талаас эхэлнэ. Бусдад нь нурууны тавилтыг гуя тавилтын зарчимтай адилхан хийнэ.

2 Эхний ба дараа дараагийн эгнээний уян дээвэр наах заавар

Урт налууд эхний эгнээг тавихдаа хэвтээгээр тэгшлэхэд хялбар байх үүднээс налуугийн төвөөс эхэлж тавих нь зүйтэй. ДЖАЗ ба КАНТРИ хэлбэрийн уян дээврийг тавихдаа дараагийн эгнээний дээврийн хавтангийн хэвтээ шилжилт нь өмнөх эгнээнийхээс 15-аас 85 см хүртэлх зайд хэлбэлзэнэ. Ингэхдээ зураг сонгох тодорхой дүрэм журам дагах шаардлагатай. Гадна дээврийн бэлэн зураг нь хийсвэр байх хэрэгтэй.




УЯН ДЭЭВРИЙГ НУГАЛАХГҮЙ БАЙХ!



3 Дам нурууны буюу хажуу ирмэгийн залгаасыг бэхлэх


Хажуугийн холбоосыг металлэн ирмэг дарагчаар бэхлэдэг бөгөөд энэхүү ирмэг дарагчуудыг 30–50 мм-ээр зөрүүлж дэвсгэр хучилт дээр тавьж, 120–150 мм зайтайгаар, зөрсөн хэсгүүдэд 20–30 мм шатарчилсан байдлаар дэвсгрийн тусгай хадаасаар бэхлэнэ. Уян дээврийг тавихын өмнө нүүрний ирмэг дарагчид цавуу түрхэж дэвсгрийн хавтангийн дээд буланг тайрна.



Налууд чиг тавих

Чиг шугам нь чиглүүлж баримжаалах үүрэгтэй бөгөөд SHINGLAS-ыг хэвтээ эсвэл босоогоор тэгшлэхэд тус болж өгдөг. Үүний хажуугаар, эдгээр чиг шугам нь хэрэв налууд дэвсгрийн ямар нэгэн элемент орсон, эсвэл дэвсгрийн гадаргын налуугийн геометр алдагдсан бол SHINGLAS-ыг тэгшилж өгдөг. Босоо шугамын алхам нь уян дээврийн эгнээний өргөнтэй тохирно, харин хэвтээ шугам нь 5 эгнээ тутамд (ойролцоогоор 80 см) тэмдэглэгдэнэ.

Чиг шугамууд нь уян дээврийг бэхлэх чиг баримжаа нь болж өгдөг.



7 Хоолойг бэлтгэх




Хасах тайрах арга

Эхний эгнээний уян дээврийг бага хэвийсэн налуугаас илүү эгц налуу руу 30 см-ээс багагүй хэмжээнд зөрүүлж тавьна. Уян дээврийн хавтан бүрийг гадна дээврийн хадаасны тусламжтайгаар давхар бэхлэнэ (2). Тусгай хадаасыг хоолойн төв тэнхлэгээс 30-см-ээс бага зайд хадаж болохгүй (1). Ингэж дээврийн бага хэвийсэн налуу хучигдана. Дараа нь илүү эгц налуу дээрх шохойн шугам дээр «ажиллана» (3). Шохойн шугамаас залгаас хотгорын (3) төв тэнхлэг хүртэлх (1) зай нь 7–8 см байна. Уян дээвэр нь илүү эгц налууугаас шохойн шугамын дагуу тайрагдана (3). Усыг хотгор рүү зайлуулахын тулд уян дээвэр бүрийг хасаж тайрах зайлшгүй шаардлагатай бөгөөд (4) 10 см хэмжээтэйгээр, хамгийн ихдээ 1 мм зузаантайгаар битумэн цавууг өөрөө наалддаг давхаргагүй хэсэгт түрхэнэ (5).

Нээлттэй арга

Хоолойн тэнхлэгийн дагуу ANDEREP (өөрөө наалддаг) суурь дэвсгэр хучлагын дээр хоолойн хучлага ТехноНИКОЛЬ-г хэвтээгээр 2–3 см-т шилжилттэйгээр суурилуулна. Хоолойн хучлагын 10 см өргөнд ард талын периметрийн дагуу ТехноНИКОЛЬ битумэн цавуугаар цавуудна. Нүүрэн талаас хоолойн хучлагыг захын хэсгээсээ 2–3 см зайтай, 20–25 см алхамтайгаар гадна дээврийн тусгай хадаасаар хадна.


Эгнээний уян дээвэр нь хоолойн хучлагын гадна тавигдах бөгөөд тайралтын (3) шугам хүртэл хоолойн тэнхлэг тийш замбараагүй байдлаар угсрагдана (1). Уян дээвэр бүр гадна дээврийн хадаасны тусламжтайгаар дээд талын хэсэгт давхар бэхлэгдэнэ (2). Тусгай хадааснуудыг хоолойн төв тэнхлэгээс 30 см ойр зайд хадахгүй (1). Үүний дараа уяны тусламжтайгаар 2 зураас буюу шугам хоорондын зай гаргана (3). Дараа нь эгнээний уян дээврийг зураас буюу шугамын дагуу зүснэ. Ус зайлуулах хоолой руу усыг хөөхийн тулд уян дээвэр бүрийн дээд буланг заавал хасаж тайрна (4) мөн 10 см хэмжээтэйгээр битумэн цавууг өөрөө наалддаг давхаргагүй хэсэгт түрхэнэ (5). Хоолойн тэвшний өргөн нь байшин, барилгын байршлаас шалтгаалан 5-аас 15 см хүртэл хэлбэлзэнэ.



6 Нэвтрэлтийг гүйцэтгэх

Утаа ба агааржуулах хоолойн эргэн тойрныг битүүлэхийн тулд хоолойн хучлага эсвэл зэвэрдэггүй метал хучлагаар хэв хийнэ.

Тодорхой газруудад гаргаж авсан хэвийн нугалж эсвэл зүсэж тааруулна. Хоолойн хучлагын ар талд 500 мм-ээс багагүй өргөнтэй ТехноНИКОЛЬ битум цавуу түрхэнэ (цавуу нь хоолойн хучлагын хэвийн бүхий л гадаргад хамгийн ихдээ 1 мм зузаантайгаар түрхэг-дэнэ). Зурвасын хана руу багадаа 300 мм-ээс эхэлнэ. Эхлээд нүүрэн талын хэвийн тухайн эгнээний уян дээвэрт тохируулан угсарна. Дараа нь уян дээврийн доорх зүүн ба баруун хэсгийг тохируулан хийнэ. Сүүлд нь ар талын хэвийн угсарна. Угсрахдаа усны урсацын зарчмыг баримтлах шаардлагатай. Баруун, зүүн, мөн ар талын хэсгүүдэд 8 см-ийн өргөнтэй тэвш хийж гүйцэтгэнэ. Эгнээний уян дээврүүдийн нийлэх хэсэгт өөрөө наалддаг давхаргагүй хэсгүүдэд 10 см-ийн хэмжээтэй ТехноНИКОЛЬ битумэн цавууг түрхэж, мөн ус зайлуулахын тулд булангуудыг тайрч өгнө. Утаа болон агааржуулалтын хоолойн ард цас хуримтлагдахаас урьдчилан сэргийлж, хэрэв тэдгээрийн хөндлөн огтлол 500x500 мм-ээс хэтэрсэн мөн тэдгээр нь налуу тууш байрласан байвал шуудуу бий болгох хэрэгтэй.



Арга №2

Минжний сүүл, Трио, Соната болон Лууны шүд зүсэлтүүдийн хувьд нурууны уян дээврийг эгнээний уян дээврээс зүсэн авч болно. Тавих үед ард талд өөрөө наалддаг давхарга байхгүй газарт ТехноНИКОЛЬ цавууг түрхэж өгнө. Бусад тохиолдолд гуя, нурууны угсралт нь нурууны ирмэг дарагч уян дээврийг ашиглан угсрахтай адил хийгдэнэ.

Анхаар: Цууралт үүсэхээс урьдчилан сэргийлж ойролцоогоор 10 см-ийн диаметртай хиймлээр халаасан метал труба нь дээр нугалаа хийж өгнө.

